



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/265

Мандалговь

Дундговь аймгийн түүхийн ном бүтээх  
ажлыг зохион байгуулах хэсгийг  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.8 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн хүрээнд аймгийн түүхийн ном бүтээх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Эрдэнэ-очир (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Гишүүд:

Ч.Болдбаатар (Түүхийн ухааны доктор)

М.Бямбажав (Музейн захирал)

П.Цэгмэд (Соёлын гавьяат зүтгэлтэн, зураач)

С.Пүрэвсүрэн (Соёлын гавьяат зүтгэлтэн, сэтгүүлч)

М.Энхбат (Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн)

Л.Цэвээнравдан (Элгэмсэг дотно Дундговь холбоо ТТБ-ын дэд тэргүүн)

Б.Балжинням (Түүхч, доктор, профессор)

Нарийн бичгийн дарга: А.Нансалмаа (Төв номын сангийн захирал)

2. Аймгийн түүхийн ном бүтээх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, номыг гардан хийх иргэнтэй гэрээ байгуулах, эх бэлтгэх, хэвлүүлэх ажлыг зохион байгуулахыг ажлын хэсэг (Н.Эрдэнэ-Очир)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/21 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210900